


Сант сумын Засаг даргын 2022 оны 09
дугаар сарын 09-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Б.Адъяатогтох- Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Т.Цэндмаа- Архив бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: О.Ганпүрэв- Засаг даргын орлогч

Г.Бат-Эрдэнэ- Засаг даргын Тамгын газрын дарга

Ч.Ганчимэг- Сургуулийн захирал

Б.Соёлмаа- Эрүүл мэндийн төвийн дарга

Х.Мөнхцэцэг- Цэцэрлэгийн эрхлэгч

Г.Буяントогтох- Хууль, эрх зүйн мэргэжилтэн

Б.Отгонбат- Соёлын төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Отгонбат- Санхүү албаны дарга

Хэсгийн төлөөлөгч

Х.Гантуяа- Мал эмнэлгийн Улсын байцаагч

Ч.Баярбат- Газрын даамал

Багийн Засаг дарга нар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 4/18

Сант сум

Шатахуун, шатах тослох материал
нийлүүлэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний 01 дүгээр зөвлөмжийн дагуу Сант сумын Засаг даргын Тамгын газрын шатахуун, шатах тослох материал нийлүүлэгчийг шалгаруулах үнийн саналыг "Хавхтын ус ББН"-ийн санал болгож буй үнээр гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Хэлэлцээр хийж гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.



108000000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 819

Майхан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.11, 15.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аюулгүй галлагаа” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Г.Батзаяа (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Гишүүд: Д.Батбаяр (Цариг багийн Засаг дарга)

О.Алтангэрэл (Цахиурт багийн Засаг дарга)

С.Жаргалсайхан (Улаан-Овоо багийн Засаг дарга)

Д.Чанцал (Залаа багийн Засаг дарга)

Ц.Энхболд (Майхан багийн Засаг дарга)

Т.Санлигмаа (Эрүүл мэндийн нийгмийн ажилтан)

Ц.Бадамжаргал (Сургуулийн нийгмийн ажилтан)

Б.Мөнхзул (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Бат-Эрдэнэ (Цаг уурын мэргэжилтэн)

2. Аяны хүрээнд хийгдэх ажлыг чанартай гүйцэтгэж, хугацаанд нь Засаг даргад тайлагнахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.



Б.АДЬЯАТОГОХ

106000000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 120

Майхан

Г Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ
зохион байгуулахыг хориглох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 57 дугаар тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хориглосны дагуу 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Ганпүрэв), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Мөнхзул) нарт тус тус даалгасугай.

ДАРГА
Б.АДЬЯАТОГОХ

1360000000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 4/21

Майхан

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт явуулах журам” сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Майхан 5 дугаар багт худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар 96 мкв газрыг сумын Засаг даргын Тамгын газарт 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ч.Баяrbat)-д үүрэг болгосугай.



106000004

D:My.Doc.Zahiramj.zasag darga



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 4/22

Майхан

Г Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Японы Хүүхдийг Ивээх сангийн хэрэгжүүлэх “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төслийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Төслийн сумын зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Лувсанбалдан (Насан туршийн боловсролын нэгжийн багш)

Хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан: Ч.Ганчимэг (Сургуулийн захирал)

Гишүүд: Г.Буянтогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Э.Эрдэнэчимэг (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн)

И.Алтанцэцэг (Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын менежер)

З.Баасансүрэн (Дотуур байрны багш)

Я.Дагмидмаа (Эцэг, эхийн төлөөлөл)

О.Алтангэрэл (Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч)

В.Мөнхсоёл (Залуучуудын холбооны гишүүн)

Н.Пунцаг (Сайн дурын идэвхтний төлөөлөл)

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг жилийн эцэст сумын Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг “Төслийн сумын зөвлөл”-ийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АДЬЯАТОГОХ

100000004



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар Нийзээ

Сант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн "Журам батлах тухай" 282 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын саналыг эрэмбэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Энхтуяа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Г.Батзаяа (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

М.Отгонбат (Санхүү албаны дарга)

Г.Буяントогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Ч.Баярбат (Газрын даамал)

Э.Эрдэнэчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Н.Пунцаг (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

О.Мягмарсүрэн (Иргэний төлөөлөл)

2. Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг журмын дагуу нэгтгэн эрэмбэлж, дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.



100000004



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 1/24

Майхан

Г Коронавируст халдварт (Ковид-19)-ын
тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн "Коронавируст халдварт (Ковид-19)-ын тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай" А/73 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын хэмжээнд Гашгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-ийг цуцалсантай холбогдуулан коронавируст халдварт (Ковид-19)-ын "Шар түвшин"-д 2022 оны 02 дугаар сарын 17-ны-ий өдрөөс эхлэн шилжүүлсүгэй.
2. Коронавируст халдварт (Ковид-19)-ын эсрэг хариу арга хэмжээнд гамшгаас хамгаалах тусламж үйлчилгээнд тасалдал, доголдол үүсэх, хариуцлага, хяналт сурлах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Бат-Эрдэнэ), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Б.Соёлмаа) нарт даалгасугай.
3. Бүх шатны боловсролын байгууллагын орчинд халдварт тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, багш, сургууль, цэцэрлэгийн захиргаа болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ч.Ганчимэг), Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч (Х.Мөнхцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай" А/155 дугаар захирамжийг 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Ганпүрэв)-д даалгасугай.





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

10.02. оны 08 сарын 21 өдөр

Дугаар 11/25

Майхан

Г Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, Геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Сумын хаягийн зураг гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн жагсаалтыг батлах тухай” 22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХХI.I.57-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдагдсан Сэргээнгийн Жавзмаагийн өмчилсөн газрын мэдээллийг өөрчилсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ч.Баяrbat)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АДЬЯАТОГОХ

100000004



Сант сумын Засаг даргын
дугээр сарын /
оны /-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Өмчилсөн газрын мэдээлэл өөрчилсөн иргэдийн нэрийн жагсаалт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 126

Майхан

Г Жендерийн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендерийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, Хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий Жендерийн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод төсвийн хамт тусгулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр ханганд ажиллахыг Жендерийн дэд хорооны дарга (О.Ганпүрэв)-д даалгасугай.



ДАРГА

Б.АДЬЯАТОГОХ

108000005

Сант сумын Засаг даргын 2022 оны *Од.*
дугаар сарын *23* ны өдрийн *12* дугаар
захирамжийн хавсралт

ЖЕНДЕРИЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Салбар хорооны дарга: Б.Адъяатогтох (Сумын Засаг дарга)
Салбар хорооны дэд дарга: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Мөнхзул (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

М.Отгонбат (Санхүү албаны дарга)

Б.Соёлмаа (Эрүүл мэндийн төвийн эмч)

Ч.Ганчимэг (Сургуулийн захирал)

-00-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1/27

Сант сум

“Илүүдэл жингүй Эртэч-Монгол” аян
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын 2.2.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн “Өвөрхангай аймгийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны “Илүүдэл жингүй Эртэч-Монгол” аян зохион байгуулах тухай A/69 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- “Илүүдэл жингүй Эртэч-Монгол” аянг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.
- Аянд төрийн байгууллагуудын биеийн тамир, спортын хамтлагууд болон аж ахуйн нэгжүүдийг идэвхтэй оролцуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ганпүрэв)-т үүрэг болгосугай.



108030003

D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны 13
дугаар сарын 01-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

**“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ-МОНГОЛ АЯН”
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: О.Ганпүрэв (Сумын Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д.Лувсанбалдан (Насан туршийн боловсролын нэгжийн багш)

Гишүүд: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Отгонбат (Соёлын төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Санлигмаа (Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан)

Сургуулийн нийгмийн ажилтан

Багийн Засаг дарга нар

-оо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/28

Майхан

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дүгээр сарын 17-ны өдрийн 5/03 дугаар /газар зохион байгуулалтын/ төлөвлөгөө батлах тухай/ тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ж.Пүрэвсүрэн, Г.Дуламжав, Г.Батбаяр, А.Хүрэлбаатар, О.Нямдаваа, Ц.Анхбаяр гэсэн 6 иргэнд өвөлжөө, хаваржааны доорхи газрын зориулалтаар хавсралтад заасан газрын байршилд 30 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрх олгосугай.
 - 2.Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ч.Баярбат) –д үүрэг болгосугай.

ДАРГА

Б. АДЪЯАТОГОХ

1000000058

Сант сумын Засаг даргын
Хийжүүлэх
Дугаар сарын
Нийтийн
дугаар Захиралт

ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ДООРХИ ГАЗРЫГ ШИНЭЭР ЭЗЭМШИХ ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Газар эзэмшигчийн			Эзэмшсэн газрын					
	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Багийн нэр, дугаар	Хаяг, байршил, газар зүйн нэр	Зориулалт	Хэмжээ /м ² /	Газар зүйн солбицол
1	Амарсаная	Хүрэлбаатар	Йл66082217	Сант сум 3-р баг	Улаан-Овоо 3-р баг	Алагэрөө	Өвөлжөө	700	N 46°02'13.1" E 104°02'02.5"
2	Жагд	Пүрэвсүрэн	Йл84051215	Сант сум 3-р баг	Улаан-Овоо 3-р баг	Хавттай чулуу	Өвөлжөө	700	N 46°00'48.1" E 103°54'49.6"
3	Цэнд	Анхбаяр	Йз81032114	Төв, Угаалцайдам, 3-р баг, Хар чулгут шилгжин ирсэн 2015 он	Сант сум Залаа 4-р баг	Хөх тойромын баруун бууц	Өвөлжөө	700	N 46°12'59.77" E 103°42'23.8"
4	Очирдорж	Нямдаваа	Йл70111917	Сант сум 3-р баг	Улаан-Овоо, 3-р баг	Үрд шовгор	Өвөлжөө	700	N 46°2'01.2" E 103°52'09.3"
5	Ганбаатар	Батбаяр	Йл01231632	Сант сум 2-р баг	Цахиурт баг 2-р баг	Бумбат	Өвөлжөө	700	N 46°12'06.20" E 103°27'33.57"
6	Гомбодорж	Дуламжав	Йл55012307	Сант сум 4-р баг	Залаа баг 4-р баг	Эхэн ус	Өвөлжөө	700	N 45°57'32.0" E 103°41'16.2"



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/29

Майхан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1, 25.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Тус суманд дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах, үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Буяントогтох (Хувь, эрх зүйн мэргэжилтэн)

Г.Батзаяа (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Үзлэг шалгалтыг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, заавар зөвлөмж өгч, тайланг зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Ганпүрэв)-т даалгасугай.



Б.АДЬЯАТОГОХ

100000000

Сант сумын Засаг даргын 2022 оны 03...
дугаар сарын 15..ны өдрийн 1/30..дугаар
захирамжийн хавсралт

НОХОЙ УСТГАЛЫН ЗАРДАЛ

д/д	Зардалын нэр	Тоо хэмжээ	Үнэ	Нийт үнэ
1	Сум	2	600000	1200000
2	Буудагчийн хөлс	60	15000	900000

-00-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 4/30

Майхан

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Сумын төвийн золбин нохой устгах ажилд зарцуулах хөрөнгийг хавсралтад заасан нийт 2100000 (Хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.
- Дээрх зардлыг хур хог хаягдал орчны бохирдлын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 431

Майхан

Г Сумын хууль, эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын 2022 оны нэгдсэн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 1993 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 57 дугаар тогтоолын 3 дахь заалт, 1996 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2022 оны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Сумын эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2022 оны нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын төрийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн (Г.Буяントогтох)-д даалгасугай.

ДАРГА



Б.АДЬЯАТОГОХ

10000000

Санкт сумын Засаг даргын 2022 оны
дугаар сарын 16.-ны өдрийн 22/Дугаар
захирамжийн хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН САНТ СУМЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
АЖЛЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022.03.16

Майхан

№	Зохион байгуулах хугацаа (утираал, сар)	Хамрах хүрээ (зорилтот бүлэг)	Хурэх үр дүн	Сургалт, сурталчилгааны хэлбэр		Зохион байгуулах байгууллага, албан тушаалттан	Хамтран зохион байгуулах байгууллага, албан тушаалттан
				Сургалт, сурталчилгааны хэлбэр	Зохион байгуулах байгууллага, албан тушаалттан		
Нэг. Гамшигаас хамгаалах тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа							
1.1	Гамшигаас хамгаалах тухай хууль, Жилдээ тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Төрийн албан хаагч, Иргэд	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Иргэдэд гамшигаас хамгаалах мэдлэг олгосон байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Засаг Тамгын дарга Г.Бат-Эрдэнэ	Засаг Тамгын газрын дарга Г.Бат-Эрдэнэ
1.2	Коронавируст халдварт /ковид-19/-ын тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт сөргөн узүүлэх нөлөөллийг бууруулах тухай сургалт, сурталчилгаа	1-2 Дугаар утираалд	Төрийн албан хаагч, Иргэд	Бүх хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна	Танхим, Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	ЗДТГ-ын дарга Г.Бат-Эрдэнэ, ЭМТэвийн Нийгмийн ажилтан Т.Санлигмаа	Сумын комисс Сумын комисс
1.3	Коронавируст халдварт /ковид-19/-ын тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд	Тухай бүрт	Төрийн албан хаагч, Иргэд	Бүх хийтэд Танхим, Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Хууль, эрх зүйн мэргэжилтэн Г.Буяントогтох	Сумын комисс Сумын комисс	Сумын комисс Сумын комисс

Монгол Улсын Засгийн газар болон улсын Онцгой комиссоос гарч буй тогтоол, шийдвэрийн сургалт, сурталчилгаа	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилсан сэргийпэх хүрээнд аймаг, сумын Засаг дарга болон аймгийн Онцгой комиссоос гарч буй тогтоол, шийдвэрийн сургалт, сурталчилгаа	Төрийн албан хаагчадад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа	ЗДТГ-ын дарга Г.Бат-Эрдэнэ, ЭМТэвийн Нийгмийн ажилтан Т.Санлигмаа	Онцгой Сумын комисс
1.4	Бүх нийтэд эрх зүйн Мэдлэг олгосон байна.	Төрийн албан хаагч, Иргэд Тухай бурт	Танхим, Цахим, хэвлэл мэдээллийн хэрэгспэлээр	
2.1	Монгол Улсын засаг захиргаа, дэвсгэрийн түүний удирдлагын тухай хуулийн сургалт /шинэчилсэн найруулга/	Төрийн албан хаагчадад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа	Танхимины болон цахим Танхимины албан хаагчадад хууль хэрэгжүүлэх арга чиглэл, зөвлөмж олгосон байна.	ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Батбаяр
2.2	Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам, жинхэнэ хаягчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, ажлын гүйцэтгэл, үр мэргэшлийн унэлэх түвшинг холбогдох хууль, тогоомжийн талаарх	Хоёр. Төрийн албан хаагчадад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа	Танхимины болон цахим Танхимины албан хаагчадад хууль, эрх зүйн Мэргэжилтэн Г.Буяントгох	Засаг Тамгын даргын газрын Хууль, эрх зүйн Мэргэжилтэн Г.Буяントгох

	сургалт, сурталчилгаа					
2.3	Хөгжлийн бодлого, түүний тухай удирдлагын хуулийн сургалт /шинэчилсэн найруулга/	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна	Байгууллагын нар, бусад холбогдох албан хаагчид	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна	Танхимины болон ЗДТГ-ын дарга Г.Бат-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
2.4	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр ажил, худалдан авах тухай хууль сургалт	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид	Төрийн албан хаагчид	Санхүү албаны дарга М.Отгонбат	Аймгийн Орон нутгийн өмчийн газар
2.5	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль бусад холбогдох тогтоожмийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Төрийн албан хаагчид	Холбогдох Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Батбаяр, Хууль, эрх зүйн мэргэжилтэн Г.Буяントготх	Сумын Цагдаагийн хэсэг, хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
2.6	Жендер болон хүний эрхийн талаарх хууль тогтоожмийн сургалт, сурталчилгаа	2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид	Танхим албан хаагчдын жендерийн талаарх ойлголт Нэмэгдсэн байна.	Танхим болон Цахим мэдээллийн хэрэгслэлээр	Аймгийн Засаг даргын газрын Нийгмийн бодлогын хэлтэс
2.7	Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах сургалт, сурталчилгаа		Холбогдох төрийн байгууллагуудын алба хаагчид	Танхим албан хаагчдад хууль хэрэгжүүлэх зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим болон Цахим мэдээллийн хэрэгслэлээр	Сумдын бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг

	Авлигын эсрэг хууль, нийтийн албанц, сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт	Холбогдох төрийн байгууллагуудын хаагчид	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Батбаяр, ЗДТГ-ын дарга Г.Бат-Эрдэнэ	Төрийн байгууллагын дарга нар
2.8	Жилдээ	Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнууд, Төрийн албан хаагчид	Төрийн албан хаагчдын архивын талаарх мэдлэг ур дээшилсэн байна.	Танхим цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Танхим цахим, мэдээллийн хэрэгслэлээр
2.9	Жилдээ	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль, Тотгоомжийн сургалт	Төрийн албан хаагчдад хууль мэргэжилтэн Г.Буяントготх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, Унэлгээ дотоод аудитын хэлтэс	
2.10		Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам бусад холбогдох эрх зүйн актын сургалт	Төрийн албан хаагчдад хууль мэргэжилтэн Г.Буяントготх	Танхим цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Танхим цахим, мэдээллийн хэрэгслэлээр
		Гурав. Иргэд, олон нийтэд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа			
3.1	Монгол Улсын Үндсэн хуулийн сурталчилгаа	1 дугаар улиралд	Иргэд	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Сумын Засаг даргын Тамгын газар
3.2	Монгол Улсын засаг захирагаа, дэвсгэрийн түүний удирдлагын тухай хуулийн сургалт /шинэчилсэн найруулга/	Иргэд	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Сумын ИТХурал
3.3	Эрүүл Мэндийн тухай	Жилдээ	Иргэд	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Сумын Эрүүл ЕБС-ийн эмч

	хууль, Тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Зүйн Дээшилсэн байна.	Мэдлэг Мэдлэг	Мэдээллийн хэрэгслэлээр	Мэндийн төвийн Нийгмийн ажилтан Т.Санлигмаа	Т.Байгалмаа
3.4	Монгол Малчин үндэсний хөтөлбөрийн сургалт, сурталчилгаа (ЗГ-ын 2020 оны 34 дүгээр тогтоол)	Иргэдийн эрх зүйн Дээшилсэн байна.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасаг Ч.Баярсайхан	Мал эмнэлгийн Улсын байцаагч Х.Гантуяа
3.5	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих сургалт, хуулийн сурталчилгаа	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	ХХДУХАХ Мэргэжилтэн Э.Эрдэнэчимэг	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар,
3.6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Иргэдийн эрх зүйн Дээшилсэн байна.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Хууль, эрх зүйн Мэргэжилтэн Г.Буянтотх	Цагдаагийн хэсэг, Сумын хэрэгээс Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
3.7	Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох тогтоомжийн сурталчилгаа	Иргэдийн эрх зүйн Дээшилсэн байна.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Татварын байцаагч Т.Ишдорж	Аймгийн Татварын хэлтэс
3.8	Зөрчлийн тухай хуулийн сурталчилгаа	Иргэдийн эрх зүйн Дээшилсэн байна.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Цагдаагийн хэсэг	Сумын хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
3.9	Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Хууль хэрэгжих нөхцөл нэмэгдэнэ.	Иргэд	Цахим, хэвлэл Цахим, хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Нийгмийн бодлогын Мэргэжилтэн	Сумын булийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг

				Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Иргэд	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	ХЖДУХАХ мэргэжилтэн Э.Эрдэнэчимэг	Сумын даргын газар	Засаг Тамгын Тамгын газар
3.10	Хэрэглэгчийн хамгаалах тогтоомжийн сурталчилгаа	Эрхийг хууль, тогтоомжийн сургалт,	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.11	Нийгмийн тухай тогтоомжийн сурталчилгаа	Нийгмийн халамжийн тухай тогтоомжийн сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.12	Нийгмийн даатгал, тэтгэвэр, тухай тогтоомжийн сурталчилгаа	Нийгмийн даатгал, тэтгэвэр, тухай тогтоомжийн сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.13	Авлигаас урьдчилан сэргийпэх, гэгээрүүлэх сурталчилгаа	Авлигаас урьдчилан соён сургалт,	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.14	Газрын тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Газрын тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.15	Малын индексжуулсэн даатгалын тухай, генетик нөөцийн тухай хууль тогтоомжийн сурталчилгаа	Малын индексжуулсэн даатгалын тухай, генетик нөөцийн тухай хууль тогтоомжийн сурталчилгаа	2, 3 дугаар улиралд	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	ХАА-н дарга Ч.Баярсайхан	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.16	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг тухай сургалт, сурталчилгаа	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн хууль сургалт, сурталчилгаа	2 дугаар улиралд	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	ХЖДУХАХ мэргэжилтэн Э.Эрдэнэчимэг	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн	Аймгийн Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн
3.17	Мал хулгайлах хэрэгтэй урьдчилан сэргийлэх тухай сургалт, сурталчилгаа	Гэмт тэмцэх, сэргийлэх тухай хуулийн хууль сургалт, сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Иргэдийн зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, мэдээллийн хэрэгслэлээр	ХЭВЛЭЛ Цагдаагийн хэсэг	Сумын хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах	Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

Дөрөв. Хүүхдүүдэд, запуучуудад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа						салбар зөвлөл
4.1	Замын хөдөлгөөний аюулгүй тухай тогтоомжийн талаарх сурталчилгаа	Хүүхэд, запуучуудын эрх мэдлэг дээшилсэн байна.	Цахим, Мэдээллийн хэрэгслэлээр	Цагдаагийн хэсэг, ЕБС-ийн Нийгмийн ажилтан	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газар	
4.2	Хүний эрхийн талаарх хууль, Тогтоомжийн сургалт	Хүний эрхийн талаар суурь ойлголт, Мэдлэгтэй сургачад	Танхим цахим, Мэдээллийн хэрэгслэлээр	Нийгмийн болон хэвлэл	ЕБС-ийн Нийгмийн ажилтан	
4.3	Байгаль орчны тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа	Хүүхэд, запуучуудад, запуучууд талаар эрх зүйн мэдлэгтэй болсон байна.	Хүүхэд, запуучууд тухайн салбарын талаар эрх зүйн мэдлэгтэй болсон байна.	Танхим цахим, Мэдээллийн хэрэгслэлээр	БОАХ мэргэжилтэн Г.Батзаяа, ЕБС-ийн Нийгмийн ажилтан	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газар
4.4	Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Хүүхэд, запуучууд	Эрх мэдлэг Нэмэгдсэн байна.	Танхим хэвлэл Мэдээллийн хэрэгслэлээр	Нийгмийн болон мэргэжилтэн, ЕБС-ийн Нийгмийн ажилтан	Аймгийн Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газар
4.5	Хүүхдийн тухай сургалт, сурталчилгаа	Хүүхэд, запуучууд	Эрх мэдлэг Нэмэгдсэн байна.	Танхим цахим, Мэдээллийн хэрэгслэлээр	Нийгмийн болон мэргэжилтэн, ЕБС-ийн Нийгмийн ажилтан	Аймгийн Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газар
4.6	Гэр булийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Иргэд, ЕБС-ийн сургачид	Эрх мэдлэг олгосон байна.	Танхим цахим, Мэдээллийн хэрэгслэлээр	Нийгмийн болон мэргэжилтэн, ЕБС-ийн Нийгмийн	Сумын булийн хучирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг

					ажилтан
4.7	“Хууль” ба амьдрал цогц сургалт”-ын хөтөлбөр	Жилдээ	Иргэд, ЕБС-ийн сургачид	Эрх мэдлэг олгосон байна.	Хууль, эрх зүйн болон цахим, мэдээллийн хэрэгслэлээр
4.8	Хүүхэд чиглэлээрх тогтоомжийн хэрэгжилтийг хурээнд байгуулагдах нөлөөллийн хэмжээ	Хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгаар тасралтгүй ага	Хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	Хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан буурсан байна.	Танхим Цахим, мэдээллийн хэрэгслэлээр
4.9	Эрүүгийн хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Хүүхэд, запуучууд	Эрх мэдлэг олгосон байна.	Танхим Цахим, мэдээллийн хэрэгслэлээр
4.10	Зөрчлийн хуулийн сурталчилгаа	Тухай сургагт, Жилдээ	Хүүхэд, запуучууд	Эрх мэдлэг олгосон байна.	Танхим Цагдаагийн хэсэг
Тав.Хууль сурталчлах “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээ					
Д/д	Өдөрлөг зохион байгуулах байгууллагын Нэр	Зохион байгуулах хугацаа	Хамрах хүрээ	Зохион байгуулагдах газар	Хурэх үр дүн
5.1	Хапамж, Нийгмийн даатгал, Улсын бүртгэл, Газрын мэргэжилтнүүд	4-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авахыг хүссэн иргэн	Соёлын төв	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.
5.2	Соёлын төв	4-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Соёлын төв	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.
5.3	Хүүхэд хамгааллын хамтарсан баг	5-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авахыг	Иргэний танхим	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл

			хүссэн иргэн	өгсөн байна.
5.4	Эрүүл мэндийн төв Б.Соёлмаа	5-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авахыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. -**-
5.5	ЕБСургууль Ч.Ганчимэг	6-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. -**-
5.6	СӨББайгууллага Х.Мөнхцэцэг	6-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. -**-
5.7	ЗДТГ-ын алба М.Отгонбат	4-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авахыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Сумын ЗДТГ-ын газар
5.8	ЗДТГ-ын ХАА-н тасаг Ч.Баярсайхан	5-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Цаг уурын ажилтан Г.Бат-Эрдэнэ
5.9	Сумын Цагдаагийн хэсэг	4, 9-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. ГХУСАЗСЗөвлөл
5.10	Сумын ГХУСАЗСЗөвлөл У.Мөнхтогтох	10-р сард	Зөвлөгөө, мэдээлэл авхыг хүссэн иргэн	Өдөрлөг болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Цагдаагийн хэсэг

САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Худалдаа оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/ЗС

Майхан

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
явуулах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 сарын 17 өдөр “2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 5/03 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 1 нэгж талбарын газрын, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2022 оны 04 дүгээр сарын 18-нд зохион байгуулсугай.
3. Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг цахимаар баталгаажуулан хүлээн авч товлосон хугацаанд дуудлага худалдааг зохион байгуулахыг Газрын даамал (Ч.Баярбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА
Б.АДЬЯАТОГОХ

1080000000

D:My.Doc.Zahiramj.zasag darga